

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-92-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center"><u>Аюултай бараа</u> тээвэрлэх (Шинэчлэгдэж байгаа) /20 хуудас/ 2006 оны NZ amend.2</p>	<p align="center"><u>АЮУЛТАЙ АЧАА ТЭЭВЭРЛЭХ</u> (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) /13 хуудас (үндсэн дүрэм-51 хуудастай байсан)/ 1997 оны NZ amend.1</p>	<p align="center">ТАЙЛБАР</p>
<p>А Бүлэг-Ерөнхий зүйл 92.1. Зорилго (а) Энэ Дүрэм нь <u>аюултай барааг</u> агаараар тээвэрлэх <u>зохицуулалтын</u> шаардлагыг тогтооно.</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ 92.1. Дүрмийн зорилго ба хэрэглээ (а) Дараах эд зүйл болон бодисоос бусад <u>аюултай ачааг</u> агаарын хөлгөөр аюулгүй тээвэрлэх үйл ажиллагааг зохицуулахад энэ дүрмийн зорилго оршино: <u>1/ нислэгийн үед хүн, амьтанд эмнэлгийн тусламж үзүүлэхтэй холбогдсон зүйлс;</u> <u>2/ хөдөө аж ахуйн нислэгийн үйл ажиллагаанд зориулагдсан зүйлс;</u> <u>3/ агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын, эсхүл ИНБД-ийн шаардлагуудын дагуу агаарын хөлөгт зайлшгүй байх зүйлс;</u> <u>4/ агаарын хөлөгт тээвэрлэгдэх ослын болон авран хамгаалах тоног хэрэгсэл;</u> <u>5/ нислэгийн үйлчилгээнд, эсхүл худалдахад зориулагдсан спиртийн төрлийн ундаа, шүршдэг болон түрхдэг үнэртэй ус, тамхины асаагуур, шүдэнз;</u> <u>6/ зорчигчдын хоол, ундаанд ашиглахад зориулагдсан хуурай мөс.</u> <u>(б) Энэ дүрмийг иргэний агаарын хөлгөөр үйлдэж буй олон улсын болон орон нутгийн зорчигч тээврийн бүх нислэгт мөрдөнө;</u> <u>(в) Аюултай ачааг тээвэрлэлтэд санал болгох, тээвэрлэлтэд хүлээн авах болон агаараар тээвэрлэх үйл ажиллагаанд ИСАО-гийн “Аюултай ачааны техникийн зааварчилгаа”-д заасан нөхцөл, журмуудыг дагаж мөрдөнө;</u> <u>(г) Өөр төрлийн тээврийн хэрэгсэл ашиглах боломжгүй онцгой нөхцөл байдал үүссэн үед, эсхүл нийтийн эрх ашгийн үүднээс зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ИНЕГ-ын дарга, тээвэрлэлтийн үед аюулгүй ажиллагааны боломжит түвшинг хангах нөхцөлтэйгээр аливаа этгээдийг энэ дүрмийн шаардлагаас ИНД-11 “Дүрэм боловсруулах, дүрмийн шаардлагаас чөлөөлөх”-ийн дагуу чөлөөлж болно.</u></p>	<p>-Тусгай шаардлага хангасны үндсэн дээр тээвэрлэж болох барааны жагсаалтыг <u>“Техникийн зааварчилгаа”-ны Part 1 Chapter 2.2</u>-т дэлгэрэнгүй заасан тул дүрэмд хэсэгчлэн заах шаардлагагүй.</p> <p>- Зохиомол заалт, дүрмийн шаардлагыг хавтгайруулсан</p>

<p>(b) Энэ Дүрэм нь дараах эд зүйл, эсхүл бодист хамаарахгүй: (1) Техникийн зааварчилгааны 1-р Бүлгийн дагуу тусгайлан хасагдсан; эсхүл (2) нислэгт тэнцэх чадварын, эсхүл ИНД-ийн нислэгийн үйл ажиллагааны шаардлагын дагуу агаарын хөлөгт байхыг шаардсан; эсхүл <u>(3) нислэгийн үйл ажиллагааны тусгай шаардлагыг хангах зорилгоор Даргын зөвшөөрсөн.</u> <u>(c) Энэ зүйлийн (b)(2) (3)-т хамаарах агаарын хөлгийн солигдох зориулалттай эд анги болон бодисыг агаарын тээвэрлэгч техникийн зааварчилгааны Бүлэг 1-ийн Хэсэг 2.2-ын дагуу илгээхээс бусад тохиолдолд, энэ Дүрмийн дагуу тээвэрлэх ёстой.</u></p>		<p>-Орхигдуулсан заалтыг нэмсэн</p>
<p>92.3. Нэр томьёо ба товчлол Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.</p>	<p>92.3. Тодорхойлолт</p>	<p>-Нэр томьёоны тайлбар ИНД-1д орсон.</p>
<p>92.5. Нөөц</p>	<p>92.5. Нөөц</p>	
<p>92.7. Тээвэрлэлтийн <u>ерөнхий</u> шаардлага</p> <p><u>(a) Аюултай барааг Техникийн зааварчилгааны дагуу ангилсан, баримтжуулсан, гэрчилгээжүүлсэн, тодорхойлсон, баглаж боосон, тэмдэглэсэн болон шошго зүүсэн ба тэдгээр нь Техникийн зааварчилгаанд заасан</u> илгээх нөхцөлд байгаагаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь <u>аюултай барааг</u> агаараар тээвэрлэхийг санал болгохгүй, эсхүл хүлээн авахгүй байх үүрэгтэй.</p>	<p>92.7. <u>Тээвэрлэлтэд тавигдах шаардлагууд</u></p> <p><u>(a) Аюултай ачааг агаараар тээвэрлэх, тээвэрлүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа эрхлэх Тээвэрлэгч болон ачаа тээврийн зуучлагч, тогтмол илгээгч нь дараах шаардлагыг хангасан байна:</u></p> <p><u>1/ “аюултай ачаа тээвэрлэх заавар”-ыг боловсруулж ИНЕГ-ын эрх бүхий этгээдээр хянуулж батлуулсан байх;</u> <u>2/ аюултай ачаатай холбогдсон үйл ажиллагаанд шууд оролцох аливаа этгээд нь ИНЕГ-аас баталсан хөтөлбөрийн дагуу сургалтанд хамрагдсан байх;</u> <u>3/ аюултай ачаатай холбогдсон зөрчил, осол гарсан тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх журамтай байх.</u></p> <p><u>(б) Тээвэрлэгч, ачаа тээврийн зуучлагч нь ИНЕГ-аас зөвшөөрөл аваагүй бол аюултай ачааг агаараар тээвэрлэх, тээвэрлэлтэнд хүлээн авахыг хориглоно.</u></p> <p>(в) <u>Аюултай ачааг</u> агаараар тээвэрлүүлэх этгээд нь тэдгээрийг <u>Аюултай ачаа</u>ны техникийн зааварчилгын дагуу ангилан, тээврийн бичиг баримтыг нь бүрдүүлсэн, савлаж боосон, зохих таних тэмдэг болон шошгоор хангасан байна.</p>	<p>-Техникийн зааварчилгаанд заасан.</p> <p>-ИНД-109-ийн зохицуулалттай давхардаж байна</p> <p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(b) <u>Аюултай барааг</u> Техникийн зааварчилгаа, эсхүл энэ Дүрмийн шаардлагын дагуу хүлээн авсан, тээвэрлэлтэд бэлтгэсэн болон тээвэрлэснээс бусад тохиолдолд, аливаа этгээд нь тухайн <u>барааг</u> агаараар тээвэрлэхгүй байх үүрэгтэй.</p>	<p>(г) Хүлээн авах, хадгалах болон ачиж зөөвөрлөх үйл ажиллагааг <u>Аюултай ачааны</u> техникийн зааварчилгын дагуу хийгээгүй бол аливаа этгээд нь тухайн <u>аюултай ачааг</u> агаараар тээвэрлэхгүй.</p> <p><u>(д) Тээвэрлэгч нь Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна аюултай ачаа тээвэрлэх бол Аюултай ачааны техникийн зааварчилгааны Гүравдугаар Хавсралтыг мөрдөнө.</u></p>	<p>Техникийн зааварчилгаанд заасан</p>
<p>92.9. Хориглосон аюултай бараа</p> <p>(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, хэрэв аюултай барааг Техникийн зааварчилгааны дагуу агаараар тээвэрлэхийг хориглосон бол, аливаа этгээд нь тухайн <u>аюултай барааг</u> агаараар тээвэрлэхийг санал болгохгүй, эсхүл хүлээн авахгүй байх үүрэгтэй.</p> <p><u>(b) Хэрэв Дарга тухайн эд зүйл, эсхүл бодисыг тээвэрлэхийг зөвшөөрсөн бол, аливаа этгээд Техникийн зааварчилгаанд өөрөөр тогтоогоогүй эд зүйл, эсхүл бодисыг багтаасан, аюултай барааны жагсаалтын 9, 10, эсхүл 11, 12 дугаар баганад хориотой гэж тодорхойлсон эд зүйл, эсхүл бодисыг агаараар тээвэрлэхийг санал болгох, эсхүл хүлээн авч болно.</u></p>	<p>92.9. Агаараар тээвэрлэхийг хориглосон аюултай ачаа</p> <p>(a) Аливаа этгээд нь <u>энэ дүрмийн 92.1-ийн (г)-д заасны дагуу дүрмийн шаардлагаас чөлөөлсөн</u>, эсхүл <u>аюултай ачааны техникийн зааварт илгээгч улсын зөвшөөрөлтэйгээр тээвэрлэж болохоор зааснаас бусад тохиолдолд, аюултай ачааны техникийн зааварт жирийн нөхцөлд агаараар тээвэрлэхийг хориглосон аюултай ачаа болон халдварт өвчнөөр халдварласан амьд амьтныг</u> тээвэрлүүлэхээр санал болгох, эсхүл түүнийг тээвэрлэлтэнд хүлээн авахыг хориглоно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p> <p>-Техникийн зааварчилгаанд заасан</p> <p>-Amend.2-оор нэмэлт өөрчлөлт орсон.</p> <p><u>-Техникийн зааварчилгааны Table 3-1. Dangerous Goods List болох 228 хуудсанд багтах жагсаалтын 9 болон 10, эсхүл 11 болон 12-оор хориглосон эд зүйл, эсхүл бодисыг тээвэрлэх боломж хаагдсан.</u></p>
<p>92.11. Үл хамаарал</p> <p>(a) <u>Хэрэв тухайн агаарын хөлөг нь зөвхөн цагдаагийн зорилгоор үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол, цагдаагийн ажилтан энэ Дүрмийг мөрдөхгүйгээр өөрийн ажил үүргийн хүрээнд аюултай барааг авч явж болно.</u></p> <p>(b) <u>Дараах тохиолдолд, аливаа этгээд нь энэ Дүрмийг мөрдөхгүйгээр, Ангилал-1 аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгох, эсхүл хүлээн авч болно, хэрэв:</u></p> <p><u>(1) зөвшөөрөгдсөн гүйцэтгэгч тээвэрлэлт хийхийг зөвшөөрсөн бол;</u></p> <p><u>(2) тухайн аюултай барааг:</u></p> <p><u>(i) зөвшөөрөгдсөн гүйцэтгэгчийн хяналтан дор тээвэрлэх бол; эсхүл</u></p> <p><u>(ii) зөвшөөрөгдсөн гүйцэтгэгчийн өгсөн зааварчилгааны дагуу тээвэрлэх ба зөвшөөрөгдсөн гүйцэтгэгч нь аюултай барааны тээвэрлэлтийн бүх цаг хугацаанд холбогдох дэмжлэг үзүүлэх боломжтой бол;</u></p>	<p>92.11. Нөөц</p>	<p>-Amend.2-оор нэмэлт өөрчлөлт орсон.</p>

(3) тухайн барааг тээвэрлэх аюулгүй байдлын болон онцгой нөхцөлийн журмыг тогтоосон бол;

(4) тухайн бараа нь:

(i) агаараар тээвэрлэхэд тохиромжтой нөхцөлд байгаа бол;

(ii) аюулгүй тээвэрлэлтэд зориулан хадгалж, хамгаалсан бол;

(5) агаарын хөлгөөр, тухайн нислэгийн зорилгоор зайлшгүй байх шаардлагатай зорчигчоос өөр зорчигч тээвэрлээгүй бол;

(6) тухайн нислэг нь хот, сум, эсхүл суурингийн шигүү сүүрьшлын бүсээс зайтай хийгдэх бол;

(с) Дараах тохиолдолд, аливаа этгээд нь энэ Дүрмийг мөрдөхгүйгээр зорчигчийн хоббид ашигладаг аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгох, эсхүл хүлээн авч болно, хэрэв:

(1) аюултай барааг дараах битүүмжлэлгүй агаарын хөлгөөр тээвэрлэх бол;

(i) МСТOW нь 5700 кг, эсхүл түүнээс доош жинтэй;

(ii) орон нутгийн VFR-аар үйлдэх нислэгт;

(2) тухайн аюултай бараа нь Техникийн зааварчилгааны Аюултай барааны жагсаалтын зорчигч тээвэрлэж байгаа агаарын хөлөгт тээвэрлэхийг хориглосон жагсаалтад ороогүй бол;

(3) тухайн аюултай барааг тээвэрлэх аюулгүй байдлын болон онцгой нөхцөлийн журмыг тогтоосон бол;

(4) тухайн аюултай барааг нэг бүрчлэн таньж тодорхойлсон бол;

(5) тухайн барааны аюултай шинж чанарыг хөлгийн даргад мэдэгдсэн бол;

(6) тухайн аюултай бараа нь:

(i) агаараар тээвэрлэхэд тохиромжтой нөхцөлд байгаа бол;

(ii) хэрэв тэдгээр нь хоорондоо аюултайгаар харилцан үйлчлэх магадлалтай бол, тусгаарлагдсан байх;

(iii) зөв байрлуулж, хамгаалсан ба хэрэв шаардлагатай бол, нислэгт гоожих, эсхүл гэмтэхээс сэргийлж савласан бол;

(7) агаарын хөлөгт зөвхөн тухайн аюултай бараатай холбоотой зорчигч тээвэрлэж байгаа бол.

92.13. Нисэх багийн гишүүд, эсхүл зорчигчид тавих шаардлага

Техникийн зааварчилгаанд зөвшөөрснөөс бусад тохиолдолд, аливаа этгээд аюултай барааг биедээ авч явахгүй, эсхүл агаарын хөлөгт аюултай барааг бүртгэгдсэн тээш, эсхүл гар тээшинд тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлж болохгүй.

92.13. Аюултай ачааны талаар нисэх багийн гишүүд, зорчигчдын хүлээх үүрэг

(a) Хэрэв Аюултай ачааны техникийн зааварчилгад зөвшөөрөгдөөгүй бол агаарын хөлгийн нисэх багийн гишүүд болон зорчигч агаарын хөлгийн бүхээгт аюултай ачааг биедээ, эсхүл гар тээш болон бүртгэгдэх тээшиндээ авч орохыг хориглоно.

-“Аюултай ачаа” гэснийг “аюултай бараа” гэж өөрчлөгдсөн

<p>92.15. Бараг тээвэрлэлтэд санал болгох</p> <p>(а) Эд зүйл, эсхүл бодисыг агаараар тээвэрлэхийг санал болгож байгаа этгээд нь:</p> <p>(1) хэрэв тухайн эд зүйл, эсхүл бодис нь <u>аюултай бараа</u> биш бол, гарын үсэг зурсан дараах баримт бичгийг <u>үйл ажиллагаа эрхлэгчид</u> гаргаж өгнө:</p> <p>(i) тухайн эд зүйл, эсхүл бодисыг нарийвчлан тодорхойлсон; эсхүл</p> <p>(ii) тухайн эд зүйл, эсхүл бодис нь <u>аюултай бараа</u> биш гэдгийг мэдэгдсэн; эсхүл</p> <p>(2) хэрэв тухайн эд зүйл, эсхүл бодис нь аюултай бараа бол, С Бүлгийг дагаж мөрдөнө.</p> <p>(b) Энэ зүйлийн (а)(1) нь:</p> <p>(1) шуудангийн эд зүйл, эсхүл</p> <p>(2) бүртгэгдсэн тээш, эсхүл гар тээшинд хамаарахгүй.</p>	<p>92.15. Ачааг тээвэрлэлтэд санал болгох</p> <p>(а) Аливаа эд зүйл болон бодисыг агаараар тээвэрлүүлэхээр санал болгож буй этгээд нь:</p> <p>1/ хэрэв эд зүйлс болон бодис нь <u>аюултай ачаа</u> биш бол <u>Тээвэрлэгчид</u> дараах бичиг баримтыг гаргаж өгнө:</p> <p>1.1 эд зүйлс, бодисыг нарийвчлан тодорхойлсон баримт;</p> <p>1.2 эд зүйлс, бодисууд нь <u>аюултай ачаа</u> биш болохыг нотлох баримт.</p> <p>2/ хэрэв эд зүйлс болон бодис нь <u>аюултай ачаа</u> бол энэ дүрмийн В бүлгийн шаардлагыг хангасан байна.</p> <p>(б) Энэ зүйлийн (а)-гийн 1/ дэх заалт нь шуудан, гар тээш болон шалгагдсан тээшинд хамаарахгүй.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p>
<p>92.17. Аюултай барааг саатуулах</p> <p>(а) ИНД-12-ын дагуу мэдээлсэн осол, эсхүл зөрчилтэй холбоотой, агаараар тээвэрлэхийг санал болгосон, эсхүл хүлээн авсан <u>аюултай бараа</u> нь <u>Даргын</u> саатуулсан бараанд тооцогдоно.</p> <p>(b) Дарга:</p> <p>(1) энэ зүйлийн (а)-д заасан аль ч барааг задалж үзлэг шалгалт хийж болно;</p> <p>(2) сорилт, дүн шинжилгээ хийх болон нотлох баримт болгох зорилгоор агууламжийн дээжийг авч хадгалж болно.</p>	<p>92.17. Аюултай ачааг тээвэрлэхээс татгалзах</p> <p>(а) Тээвэрлэлтэнд хүлээн авсан, эсхүл тээвэрлэлтэд санал болгосон <u>аюултай ачаа</u> нь ИНД-12-ын дагуу нислэг-техникийн осол, зөрчлийн мэдээлэлд орж байсан бол <u>Тээвэрлэгч нь тухайн аюултай ачааг тээвэрлэхээс татгалзаж, энэ тухай ИНЕГ-ын эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.</u></p> <p>(б) Энэ зүйлийн (а)-д тусгагдсан мэдэгдлийн дагуу <u>ИНЕГ-ын эрх бүхий</u> этгээд нь Тээвэрлэгчтэй хамтран дараах арга хэмжээг авна:</p> <p>1/ тухайн <u>аюултай ачааг</u> шалгаж тодруулах;</p> <p>2/ шаардлагатай бол тухайн бараанд шинжилгээ хийлгэхээр дээж авах.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>В Бүлэг - Баглаа боодлын иж бүрдэл хийх, савлах, тэмдэглэх болон шошго зүүх</p>	<p>Б БҮЛЭГ. САВЛАХ, БАГЛАХ, ТАНИХ ТЭМДЭГ БОЛОН ШОШГО ТАВИХ</p>	
<p>92.51. Баглаа боодлын иж бүрдэлд тавих шаардлага</p> <p>(а) Дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь баглаа боодлын иж бүрдэлд энэ Дүрмийн шаардлага хангасан талаар тэмдэглэгээ хийх шошго зүүх баталгаажуулах эсхүл тээвэрлэлтэд санал болгохгүй,</p> <p>(1) Техникийн зааварчилгааны дагуу үйлдвэрлэсэн хийсэн тэмдэглэсэн, хадгалсан нөхцөлийг сайжруулсан болон (засварласны аль тохирохоор);</p> <p>(2) Техникийн зааварчилгааны дагуу тест хийсэн;</p> <p><u>(3) Монгол Улсад үйлдвэрлэсэн баглаа боодлын иж бүрдлийн хувьд:</u></p> <p>(i) итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллага тест хийсэн;</p>	<p>92.51. Хайрцаг саванд тавигдах шаардлага</p> <p>(а) <u>Аюултай ачаа</u>нд зориулагдсан хайрцаг сав нь дараах шаардлагыг хангаагүй бол аливаа этгээд хайрцаг саван дээр таних тэмдэг болон шошго тавьж баталгаажуулахгүй:</p> <p>1/ <u>аюултай ачаа</u>ны техникийн зааварчилгад тусгагдсан шаардлагын дагуу үйлдвэрлэж, бэлтгэж, засварлаагүй бол;</p> <p>2/ <u>аюултай ачаа</u>ны техникийн зааварчилгын дагуу эрх бүхий этгээдээр шалгагдаагүй бол.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p>

<p><u>(ii) Ангилал-7 аюултай бараанаас бусад нь Даргаар зөвшөөрөгдсөн;</u> <u>(iii) Ангилал-7 аюултай бараа нь Үндэсний цацраг идэвхт материалын лабораториор зөвшөөрөгдсөн.</u> <u>(4) Монгол Улсад үйлдвэрлээгүй баглаа боодлын иж бүрдлийн хувьд ИCAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсад үйлдвэрлэсэн ба тест хийсэн байх.</u> <u>(b) Энэ зүйлийн (a)(3) болон (4) нь Техникийн зааварчилгаанд тест хийсэн байхыг шаардаагүй баглаа боодолд хамаарахгүй.</u></p>		<p>- Amend.1 –ээр нэмэлт өөрчлөлт орсон.</p>
<p><u>92.53. Баглаа боодлын иж бүрдлийн зөвшөөрөл</u> <u>(a) Энэ дүрмийн 92.51(a)(3)(ii)-ын дагуу зөвшөөрөл авах, эсхүл сунгуулах хүсэлтийг, Техникийн зааварчилгааны дагуу баглаа боодлын иж бүрдлийн үзүүлэлтийн тестийн тайлангийн хамт Даргад хүргүүлэх ёстой.</u> <u>(b) Энэ зүйлийн (a)-д заасан зөвшөөрлийг дараах тохиолдолд олгож болно, хэрэв:</u> <u>(1) тухайн баглаа боодлын иж бүрдлийн үзүүлэлтийн тестийн тайлан амжилттай үр дүн харуулж байгаа бол;</u> <u>(2) хүсэлт гаргагч нь дүрэмд заасан зохих хураамжийг төлсөн бол.</u> <u>(c) Энэ зүйлийн (b)-гийн дагуу олгосон зөвшөөрөл нь:</u> <u>(1) 5 хүртэлх жилийн хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно;</u> <u>(2) хугацаа дуусах, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй хэвээр байна;</u> <u>(3) тухайн баглаа боодлын иж бүрдэлд Техникийн зааварчилгааны дагуу байрлуулах тэмдэглэгээг зааж өгнө.</u></p>	<p><u>92.53. Нөөц</u></p>	<p>-Amend.1 –ээр нэмэлт өөрчлөлт орсон.</p>
<p><u>92.55. Савлагаанд тавих шаардлага</u> <u>Аюултай барааг агаараар тээвэрлэхээр савлаж байгаа этгээд нь:</u> <u>(1) тухайн барааг Техникийн зааварчилгааны дагуу савлана;</u> <u>(2) Техникийн зааварчилгаанд өөрөөр зааснаас бусад тохиолдолд, тухайн баглаа боодлын иж бүрдэлд дараах шаардлагыг бататгана:</u> <u>(i) холбогдох тестэд заасны дагуу хэрэглэдэг байх;</u> <u>(ii) савлах арга, түүний хэмжээ болон тест хийгдсэн дотоод баглаа боодлын иж бүрдлийн төрлийг хамруулан, тухайн загварын маягтай бүх талаар нийцдэг байх.</u></p>	<p><u>92.55. Савлалтанд тавигдах шаардлага</u> <u>(a) <u>Аюултай ачаа</u>г тээвэрлэлтэнд зориулан савлаж буй этгээд нь тэдгээрийг <u>Аюултай ачаа</u>ны техникийн зааварчилгын дагуу бүлэглэж савласан байна.</u></p>	<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p><u>92.57. Тэмдэглэгээнд тавих шаардлага</u> <u>Агаараар тээвэрлэх аюултай барааг агуулсан баглаа боодол, эсхүл гадуур боодолд тэмдэглэгээ хийж байгаа этгээд нь тухайн баглаа боодол, эсхүл гадуур боодолд тэмдэглэгээг дараах</u></p>	<p><u>92.57. <u>Таних тэмдэг</u>, тэмдэглэгээнд тавигдах шаардлага</u> <u>(a) Савлагдсан <u>аюултай ачаа</u>нд таних тэмдэг, тэмдэглэгээ хийж буй этгээд нь таних тэмдгийг <u>Аюултай ачаа</u>ны</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>хэлбэрээр хийнэ:</p> <p>(1) Техникийн зааварчилгааны дагуу;</p> <p>(2) дараах байдлаар:</p> <p>(i) аюултай барааны оноосон нэр болон, хэрэв тохиромжтой бол техникийн нэрийг нэмэлтээр;</p> <p>(ii) тогтоосон бол, харилцан хамааралтай UN үсгээр эхэлсэн UN дугаар;</p> <p>(iii) аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгосон этгээдийн болон хүлээн авагчийн нэр, хаяг;</p> <p>(iv) Техникийн зааварчилгаанд заасан бусад тэмдэглэгээ.</p>	<p>техникийн зааварчилгын дагуу тавих ба тэмдэглэгээнд дараах зүйлийг тусгасан байна:</p> <p>1/ аюултай ачааны оноосон нэр;</p> <p>2/ нэгдсэн үндэстний дугаар /өмнө нь UN үсгийг тавина/;</p> <p>3/ аюултай ачааг илгээгч болон хүлээн авагчийн нэр хаяг;</p> <p>4/ аюултай ачааны техникийн зааварчилгад тусгагдсан бусад тэмдэглэгээнүүд.</p> <p>(б) Энэ зүйлийн (а)-д заагдсан тэмдэглэгээ нь олон улсын нислэгт англи хэл дээр бичигдсэн байна.</p>	<p>-6.3 of Annex 18.</p>
<p>92.59. Шошгонд тавих шаардлага</p> <p>Агаараар тээвэрлэх аюултай барааг агуулсан баглаа боодол, эсхүл гадуур боодолд шошго тавьж байгаа этгээд нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) баглаа боодол, гадуур боодолд Техникийн зааварчилгааны дагуу шошго тавих;</p> <p>(2) аюултай гэсэн шошго бүр нь Техникийн зааварчилгааны дагуу тухайн аюулын жинхэнэ шинж чанарыг харуулж байгааг бататгах.</p>	<p>92.59. Шошгонд тавигдах шаардлага</p> <p>(а) Аюултай ачаа агуулсан сав баглаа болон гадуур баглаа боодлын шошго нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ аюултай ачааны техникийн зааварчилгад нийцсэн байх;</p> <p>2/ шошго нь тухайн ачааны аюулын төрлийг зааж байх;</p> <p>3/ аюулын талаарх анхааруулга нь англи хэл дээр бичигдсэн байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-6.3 of Annex 18</p>
<p>С Бүлэг-Аюултай барааг тээвэрлэлтэд санал болгох</p>	<p>В БҮЛЭГ. АЧАА ИЛГЭЭГЧИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА</p>	
<p>92.101. Хамрах хүрээ</p> <p>(а) Энэ Бүлэг нь аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгох зохицуулалтын шаардлагыг тогтооно.</p> <p>(b) Аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгож байгаа этгээдийн өмнөөс энэ Бүлэгт шаардсан үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа этгээд нь тухайн үйл ажиллагааг энэ Бүлгийн дагуу гүйцэтгэнэ.</p>	<p>92.101. Нөөц</p>	<p>-Орхигдуулсан зүйлийг нөхөж оруулсан</p>

<p>92.103. Аюултай барааг тээвэрлэлтэд санал болгох <u>Аюултай бараа</u> агуулсан баглаа боодол, эсхүл гадуур боодлыг агаараар тээвэрлэхийг санал болгож байгаа этгээд нь дараах шаардлагыг бататгана:</p> <ol style="list-style-type: none"> (1) тухайн <u>аюултай барааг</u> Техникийн зааварчилгааны дагуу агаараар тээвэрлэхийг хориглоогүй байх; (2) <u>тухайн аюултай барааг энэ Бүлгийн дагуу баталгаажуулсан байх;</u> (3) <u>тухайн аюултай барааг В Бүлэгт заасан хэлбэрээр баглаж боосон, савласан, тэмдэглэсэн болон шошго зүүсэн байх;</u> (4) <u>Техникийн зааварчилгаанд шаардсан бол тухайн аюултай бараанд 92.105-ын дагуу бүрдүүлсэн багарын үсэг зурсан аюултай барааны тээврийн баримт бичиг дагалдуулсан байх;</u> (5) <u>тухайн бараа нь Техникийн зааварчилгааг өөр хэлбэрээр хангасан байх.</u> 	<p>92.103. Ерөнхий шаардлага</p> <p>(а) <u>Аюултай ачааг</u> агаараар тээвэрлүүлэх этгээд нь дор дурдсан зүйлийг шалгаж баталгаажуулсан байна:</p> <ol style="list-style-type: none"> 1/ <u>аюултай ачаа</u>ны техникийн зааварчилгад тухайн ачааг агаараар тээвэрлэхийг хориглоогүй байх; 2/ <u>аюултай ачааг</u> энэ дүрмийн Б бүлэгт заасны дагуу савлаж, таних тэмдэг болон шошго тавьсан байх. 3/ <u>аюултай ачаа</u>ны техникийн зааварчилгад шаардсаны дагуу <u>аюултай ачаа</u>ны тээврийн бичиг баримтуудыг энэ дүрмийн 92.105-т зааснаар бүрдүүлж, эрх бүхий этгээдээр баталгаажуулсан байх. 	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Орхигдсон заалтыг нөхөж оруулсан</p>
<p>92.105. Аюултай барааны тээврийн баримт бичиг</p> <p>(а)<u>Аюултай барааг</u> агаараар тээвэрлэхийг санал болгож байгаа этгээд нь 92.103(4)-ийг харгалзан, 2 хувь үйлдэж, гарын үсэг зурсан <u>аюултай барааны</u> дараах тээврийн баримт бичгийг үйл ажиллагаа эрхлэгчид хүргүүлнэ:</p> <ol style="list-style-type: none"> (1)дараах дарааллаар тухайн <u>аюултай барааг</u> зөв дүрсэлсэн: <ol style="list-style-type: none"> (i) оноосон нэр; (ii) ангилал, эсхүл тогтоосон бол Ангилал-1-ийн хувьд, нийцлийн группийг багтаасан бүлэг (division); (iii) хэрэв байгаа бол, UN үсгээр эхэлсэн UN дугаарыг; (iv) тогтоосон бол, тохирох савлах групп; (2)<u>аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгож байгаа этгээд гарын үсэг зурсан дараах мэдэгдлийг агуулсан:</u> <u>Би, энэхүү илгээх барааны агууламжийг оноосон нэрээр бүрэн гүйцэд, нягт нямбай тодорхойлсон ба олон улсын болон үндэсний холбогдох хууль дүрэмд заасан тээвэрлэлтийн тохирох нөхцөлийн дагуу ангилсан, баглаж боосон, савласан, тэмдэглэсэн ба шошго / зурагт хуудас хэрэглэсэн болохыг мэдэгдэж байна.</u> (3)<u>Техникийн зааварчилгаанд заасан нэмэлт шаардлагыг</u> 	<p>92.105. Аюултай ачааны тээврийн бичиг баримтууд</p> <p>(а) <u>Аюултай ачааг</u> агаараар тээвэрлүүлэхээр санал болгож буй аливаа этгээд нь тээврийн бичиг баримтын талаар дараах үүрэгтэй:</p> <ol style="list-style-type: none"> 1/ гарын үсэг зурж баталгаажуулсан тээврийн бичиг баримтыг 2 хувь үйлдэж Тээвэрлэгчид хүлээлгэж өгөх; 2/ <u>аюултай ачаа</u>ны техникийн зааварчилгад дурдсан аливаа нэмэлт шаардлагуудыг дагаж мөрдөх; 3/ энэ дүрэм болон <u>Аюултай ачаа</u>ны техникийн зааварчилгад тусгагдсан шаардлагуудыг хангасан тухай баталгааг бичгээр гаргах. <p>(б) Тээврийн бичиг баримтад дараах зүйлийг тусгасан байна:</p> <ol style="list-style-type: none"> 1/ ачааны оноосон нэр; 2/ ачааны ангилал болон бүлэг; 3/ нэгдсэн үндэстний дугаар /өмнө нь UN үсгийг тавих/; 4/ савлалтын багц. 	<p>-Amend.1–ээр нэмэлт өөрчлөлт орсон</p>

<p><u>хангасан;</u> <u>(b) Шаардлагатай тохиолдолд энэ зүйлийн (a)(2)-т шаардсан мэдэгдэл нь холбогдох зурагт хуудсанд заасан ишлэлийг дурдахгүй байж болно.</u></p>	<p><u>(в) Аюултай ачааны тээврийн бичиг баримтууд нь олон улсын нислэгт англи хэл дээр бичигдсэн байна.</u></p>	<p>-7.3 of Annex 18</p>
<p>D Бүлэг-Үйл ажиллагаа эрхлэгч</p>	<p>Г БҮЛЭГ. АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА</p>	
<p>92.151. Хамрах хүрээ <u>(a) Энэ Бүлэг нь дараах үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно:</u> <u>(1) үйл ажиллагаа эрхлэгч аюултай барааг хүлээн авах, тээвэрлэлтэд бэлтгэх, хадгалах, ачаалах болон үзлэг шалгалт хийх;</u> <u>(2) үйл ажиллагаа эрхлэгч тухайн аюултай барааны талаар мэдээллээр хангах.</u> <u>(b) Үйл ажиллагаа эрхлэгчийн өмнөөс энэ Бүлэгт шаардсан үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа этгээд нь тухайн үйл ажиллагааг энэ Бүлгийн дагуу гүйцэтгэнэ.</u> <u>(c) Энэ Бүлгийг тухайн үйл ажиллагаа эрхлэгчийг тодорхой эд зүйл, эсхүл бодисыг заавал тээвэрлэхийг шаардсан, эсхүл тодорхой эд зүйл, эсхүл бодисыг тээвэрлэх тусгай шаардлага хэрэгжүүлэхээс үйл ажиллагаа эрхлэгчийг чөлөөлсөн гэж тайлбарлаж болохгүй.</u></p>	<p>92.151. Нөөц</p>	<p>-Орхигдуулсан зүйлийг нөхөж оруулсан</p>
<p>92.153. Аюултай бараа хүлээн авах <u>Үйл ажиллагаа эрхлэгч нь</u> дараахаас бусад тохиолдолд, баглаа боодол, гадуур боодол, эсхүл Техникийн зааварчилгаанд зөвшөөрсөн бол, <u>аюултай бараа</u> агуулсан ачилтын нэгж төхөөрөмжийг агаараар тээвэрлэхээр хүлээн авахгүй: (1) Техникийн зааварчилгаанд тухайн баримт бичгийг шаардлагагүй гэж зааснаас бусад тохиолдолд, 92.105-д заасан <u>аюултай барааны</u> тээврийн баримт бичгийн 2 хувийг дагалдуулсан; (2) баглаа боодол, гадуур боодол, эсхүл <u>ачилтын нэгж төхөөрөмжид:</u> (i) 92.163-ын дагуу үзлэг хийсэн; (ii) 92.57 болон 92.59-ийн дагуу тэмдэглэж шошго зүүсэн.</p>	<p>92.153. Аюултай ачааг тээвэрлэлтэд хүлээн авах (а) Тээвэрлэгч нь дараах шаардлага хангагдаагүй <u>аюултай ачааг</u> тээвэрлэлтэнд хүлээн авахыг хориглоно: 1/ <u>аюултай ачаа</u>ны техникийн зааварчилгад тусгайлан зааснаас бусад тохиолдолд, энэ дүрмийн 92.105-д дурдсан <u>аюултай ачааны</u> тээврийн бичиг баримтыг 2 хувь бүрдүүлэн хавсаргасан байх; 2/ сав баглаа, гадуур баглаа боодол болон <u>ачааны чингэлэгүүд</u> нь: 2.1 энэ дүрмийн 92.163-ын дагуу шалгагдсан байх; 2.2 энэ дүрмийн 92.57 ба 92.59-ийн дагуу таних тэмдэг, шошго тавигдсан байх. <u>(б) Тээвэрлэгч нь энэ зүйлийн (а)-д заасныг</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан -Unit load device- ачааны чингэлэг гэснийг ачилтын нэгж төхөөрөмж гэж өөрчилсөн. -Чингэлэгт тавцан (plate) багтахгүй.</p>

баталгаажуулахын тулд аюултай ачааг тээвэрлэлтэд хүлээн авахдаа Шалгах хуудсыг хэрэглэнэ.

92.155. Хүлээн авах шалгалт

Аюултай барааг агаараар тээвэрлэхээр хүлээн авч байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь:

(1) дараах шаардлагыг бататгах хүлээн авах шалгах хуудсыг ашиглана:

(i) 92.153-ын шаардлага хангасан байх;

(ii) тухайн аюултай барааны тээврийн баримт бичиг нь 92.105-ын шаардлага хангасан байх.

(2) хүлээн авах шалгалтын үр дүнгийн бүртгэлийг хөтөлнө;

(3) энэ зүйлийн (2)-т шаардсан бүртгэлийг минимум 6 сарын хугацаанд хадгална.

92.155. Нөөц

92.187. Бичиг баримтын хадгалалт

(а) Тээвэрлэгч нь аюултай ачааны тээврийн бичиг баримт, аюултай ачааг хүлээн авсан шалгах хуудас болон агаарын хөлгийн даргад бичгээр өгсөн мэдээлэл зэрэг бичиг баримтын нэгээс доошгүй хувийг тухайн нислэг үйлдсэн өдрөөс хойш 6 сараас доошгүй хугацаагаар хадгална.

-Дугаар зөрүүлсэн.

-Байрлал алдсан тул зөөж тавьсан.

92.157. Агаарын хөлөгт ачаалах хязгаарлалт

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, үйл ажиллагаа эрхлэгч нь аюултай барааг зорчигчтой агаарын хөлгийн бүхээгт, эсхүл агаарын хөлгийн нислэгийн бүхээгт тээвэрлэхгүй.

(b) Үйл ажиллагаа эрхлэгч нь:

(1) хэрэв Техникийн зааварчилгааны дагуу хийхийг зөвшөөрсөн бол, зорчигч, эсхүл нисэх багийн гишүүнийг бүртгэгдсэн тээш, эсхүл гар тээшинд, эсхүл биедээ аюултай бараа авч орохыг зөвшөөрч болно;

(2) хэрэв Техникийн зааварчилгаанд тусгайлсан баглаа боодлоор хийхийг зөвшөөрсөн бол, цацраг идэвхт материалыг зорчигчтой агаарын хөлгийн бүхээгт, эсхүл агаарын хөлгийн нислэгийн бүхээгт тээвэрлэхийг зөвшөөрч болно;

(3) тухайн агаарын хөлөг В ангиллын ачааны бүхээгээр тоноглогдоогүй үед, хэрэв орон нутгийн нислэг үйлдэх бол, дараах аюултай барааг зорчигчийн бүхээгийн ачааны хэсэгт тээвэрлэж болно:

(i) Ангилал-1, Бүлэг 1.4 Групп S-д хамаарах тэсрэмтгий бодис;

(ii) Ангилал-2, Бүлэг 2.2, шатамхай бус, хоргүй хий;

(iii) Ангилал-3, шатамхай шингэн /савлах Групп - III/;

(iv) Ангилал-4, Бүлэг 4.1- шатамхай хатуу бодис / савлах Групп - III/;

(v) Ангилал-5, Бүлэг 5.1- исэлдэгч бодис / савлах Групп - III/;

(vi) Ангилал-6, Бүлэг 6.1- хортой бодис / савлах Групп - III/;

(vii) Ангилал-7, минимум тусгаарлах зайг ханган ачсан цацраг идэвхт материал;

92.157. Нөөц

92.159. Аюултай ачааг агаарын хөлгийн бүхээгт тээвэрлэх

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, Тээвэрлэгч нь аюултай ачааг нисэх багийн бүхээг болон зорчигчийн бүхээгт байрлуулж тээвэрлэхийг хориглоно.

(б) Тээвэрлэгч нь дараах нөхцөлд аюултай ачааг нисэх багийн бүхээг болон зорчигчдын бүхээгт байрлуулан тээвэрлэж болно:

1/ аюултай ачааны техникийн зааварчилгад тухайн аюултай ачааг биедээ, эсхүл гар тээш болон бүртгэгдэх тээшиндээ авч явахыг зөвшөөрсөн бол;

2/ орон нутгийн нислэг үйлдэх агаарын хөлөг нь В ангиллын (утаа болон гал дохиологч системтэй) ачааны тасалгаагүй бол дараах аюултай ачааг зорчигчдын бүхээг дэх ачаа байрлуулах хэсэгт тээвэрлэнэ:

1 дүгээр ангиллын 1.4-р бүлэг, S группийн тэсрэмтгий бодис;

2 дугаар ангиллын 2.2-р бүлэг, шатамхай бус, хоргүй хий;

3 дугаар ангилал, шатамхай шингэн /савлалтын багц– III/;

4 дүгээр ангиллын 4.1-р бүлэг, шатамхай хатуу бодис /савлалтын багц – III/;

